

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 2

Хуралдаан 2013 оны нэгдүгээр сарын 24-ны өдрийн 14 цаг 24 минутад эхэлж, 15 цаг 09 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 44 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Яамдын төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгийн 2013 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн ХЭГ/66 тоот албан бичиг, Яамдын төрийн нарийн бичгийн дарга нарын ажлын байрны тодорхойлолт, тухайн ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирүүлснийг хэлэлцээд, Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг 2013 оны хоёрдугаар сарын 25-ны өдрөөс эхлэн, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2013 оны хоёрдугаар сарын 21,25,26-ны өдөр зохион байгуулахаар тогтов.
2	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын дарга Ч.Сайханбилэгийн 2013 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн ХЭГ/87 тоот албан бичиг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд даргын ажлын байрны тодорхойлолт, тухайн ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд

		<p>ирүүлснийг хэлэлцээд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд даргын албан тушаалд томилогдох удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг 2013 оны хоёрдугаар сарын 25-ны өдрөөс эхлэн, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2013 оны хоёрдугаар сарын 21-22-ны өдөр зохион байгуулахаар тогтов.</p>
--	--	--